



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А79

Улаанбаатар хот

Зөвлөх баг томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийг үндэслэн, улаанбурхан, томуу, томуу төст өвчний тархалтыг хязгаарлах эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбурхан, томуу, томуу төст өвчний тархалтын тархвар зүйн зөвлөх багийн гүйцэтгэх үүрэг, бүрэлдэхүүнийг нэгдүгээр, эмнэл зүйн зөвлөх багийн гүйцэтгэх үүрэг, бүрэлдэхүүнийг хоёрдугаар, санхүүгийн зөвлөх багийн гүйцэтгэх үүрэг, бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвлөх багийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг зохицуулж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Т.Баярсайхан)-т үүрэг болгосугай.

3. Улаанбурхан, томуу, томуу төст өвчний дэгдэлт, хүндрэл, нас баралтад тухай бүр дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагуудад багаар очиж зөвлөлөгөө, зөвлөмж өгөх төлөвлөгөө гарган ажиллахыг багийн ахлагч нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (С.Энхболд)-д үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080277

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 14 өдрийн
А79 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

1. Тархвар зүйн зөвлөх багийн гүйцэтгэх үүрэг:

- Улаанбурхан өвчний хэтийн төлөв, тархвар зүйн тооцооллыг гарахад дэмжлэг үзүүлэх.
- Улаанбурхан өвчний дэгдэлтийн судалгаа хийх, нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулахад мэргэжил арга зүйн удирдамжаар хангах.
- Улаанбурхан өвчний тархвар зүй, вирус судлалын талаар хамтарсан судалгаа хийх.
- Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтын үр дүнг тооцон, цаашдын чиглэл гаргах.
- Улаанбурхан өвчний дэгдэлтийн дараах үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх.
- Мэдээлэл, сургалт, сурталчилгааг арга зүйн удирдлагаар хангах.

2. Тархвар зүйн зөвлөх багийн бүрэлдэхүүн:

Багийн ахлагч:

П.Оюунцэцэг, ЭМСЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

Д.Нарангэрэл, ЭМСЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Д.Нямхүү, ХӨСҮТ-ийн ерөнхий захирал,

А.Амбасэлмаа, ХӨСҮТ-ийн ХӨТСА-ны дарга

Б.Дармаа, ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн эрхлэгч АУ-ны доктор

Г.Сүрэнханд, ХӨСҮТ-ийн зөвлөх

Б.Ганбаатар, Глобал удирдагч их сургуулийн
багш, АУ-ны доктор, профессор


Л.Туул, Вирус судлалын нийгэмлэгийн гишүүн
АУ-ны доктор,

Д.Гантулга, "Итгэл эрүүл мэнд" эмнэлгийн
гүйцэтгэх захирал, АУ-ны доктор,

Л.Содбаяр, Дэлхийн эрүүл мэндийн
байгууллагын ажилтан /зөвшилцснөөр/

Г.Сүрэнчимэг, НҮБ-ын Хүүхдийн сангийн
ажилтан /зөвшилцснөөр/.

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 14 өдрийн
А/29 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



1. Эмнэл зүйн зөвлөх багийн гүйцэтгэх үүрэг:

- Зөвлөх баг нь 7 хоног бүрийн Лхагва гаригт ХӨСҮТ-ийн хүнд хэлбэрийн улаанбурханаар өвчилсөн хүүхдэд тойрон үзлэг хийж, зөвлөгөө өгнө.
- Зөвлөх багууд нь хамтран 14 хоног бүрийн Пүрэв гаригт аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудтай Улаанбурхан, томуу, томуу төст өвчний цаг үеийн байдлаар цахим хурал зохион байгуулж, зөвлөгөө өгнө.
- Зөвлөх баг нь шаардлагатай тохиолдолд мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдийг татан оролцуулж хамтын шийдвэр гаргана.
- Улаанбурхан, томуу, томуу төст өвчний үед үзүүлэх эмчилгээ, оношилгооны зааврыг боловсронгуй болгоход арга зүйн дэмжлэг үзүүлэх.
- Эмч, мэргэжилтнүүдэд улаанбурхан, томуу, томуу төст өвчний чиглэлээр сургалт зохион байгуулна.
- Зөвлөх багийн гишүүд нь багийн ахлагчийн гаргасан хуваарийн дагуу эмнэлгүүдэд зөвлөгөө өгнө.

2. Эмнэл зүйн зөвлөх багийн бүрэлдэхүүн:

Багийн ахлагч:

Л.Зэндмаа, ЭМСЯ-ны Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

С.Гантуяа, ЭМСЯ-ны Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн

М.Оюунчимэг, ЭМСЯ-ны Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Ц.Алтантуяа, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал,

Р.Батсолонго, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн
эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн
эрхлэгч,

Б.Энхтайван, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
эрчимт эмчилгээний тасгийн их эмч,

О.Энхчимэг, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
Мэдрэлийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч,

Б.Болормаа, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
Мэдрэлийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч,

Т.Болормаа, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын
тасгийн эрхлэгч,

Б.Ундрал, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын
тасгийн их,

Б.Ариунхишиг, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн
эмнэлгийн Амьсгалын эрхтний эмгэг судлалын
тасгийн их эмч,

Л.Дашиймаа, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
бөөрний тасгийн их эмч,

Э.Гүенбаатар, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн
эмнэлгийн бөөрний тасгийн их эмч,

О.Солонго, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
Амьсгалын эрхтний эмгэг судлалын тасгийн
эрхлэгч,

Б.Батсүх, ХӨСҮТ-ийн Яаралтай тусламжийн
тасгийн эрхлэгч,

Н.Сарантуяа, ХӨСҮТ-ийн Яаралтай тусламжийн
тасгийн их эмч,


Б.Бурмаа, ХӨСҮТ-ийн Агаар дуслын эмгэгийн
тасгийн их эмч,

Ч.Эрдэнэчимэг, "Интермед" эмнэлгийн хүүхдийн
тасгийн их эмч, /зөвшилцсөнөөр/

Д.Агиймаа, АШУҮИС-ийн ХАТ-ийн багш, АУ-ны
доктор /зөвшилцсөнөөр /

Д.Мөнхзол, АШУҮИС-ийн ХАТ-ийн баш, АУ-ны
доктор /зөвшилцсөнөөр/.

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 14 өдрийн
АБ дугаар тушаалын 3 дугаар
хавсралт



1. Санхүүгийн зөвлөх багийн гүйцэтгэх үүрэг:

- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн яаралтай тусламжийн тасгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг яаралтай зохион байгуулах.
- Нэмэлт дархлаажуулалтанд шаардагдах хөрөнгийн зардлыг тооцож боловсруулан Засгийн газарт хүргүүлэх.
- Улаанбурхан, томуу, томуу төст өвчний үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллах.

2. Санхүүгийн зөвлөх багийн бүрэлдэхүүн:

Багийн ахлагч:

Т.Баярсайхан, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Гишүүд:

М.Уранчимэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Д.Нарантуяа, Санхүү, эдийн засгийн хэлтсийн мэргэжилтэн,

О.Батбаяр, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн,

Д.Ганзориг, ЭМСЯ-ны ЭМБХЗГ-ын НЭМХ-ийн мэргэжилтэн

Н.Шинэхүү, ХӨСҮТ-ийн эдийн засагч